

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Том. XXXIII (359)

2011

113-117

МОНГОЛЧУУДЫН ИМ ТАМГЫН УТГА СОЁЛЫН ТУХАЙД

Тогтох*

Агуулгын товч

Тус өгүүлэлд монгол үндэстний уламжлалт мэдээ зангийн уламжлалын чухал нэгэн хэлбэр болох им тамгын тухайд мэдээллийн хэлбэрийг ашиглан өгүүлэхийг зорьсон болно. Монгол тамга нь монголчуудын соёлын түүхийг хадгалж ирсэн бөгөөд түүнд монголчуудын соёл сэтгэхүй, мэдлэг ухамсар зэргийг харуулсан байдаг.

Зангилгаа үг: Монгол им тамга, мэдээ зангийн уламжлал

Монгол тамга нь түүхэн хөгжлийн явцад овог аймгийн тамгаас тэмдгээс улбаалан, цаашлаад таван хошуу малын тамга тэмдэг болтлоо дэлгэрэн хөгжсөн байна. Эдүгээ таван хошуу малд хэрэглэж буй тамгыг угсаатанзүйн үүднээс уламжлалт ба уламжлалт бус, үг зүйн талаасаа монгол (соёмбо болон кирилл), манж, төвд, кидан, хятад үсгийн тамга болон араб тооны тамга гэх мэтээр ангилахаас гадна хэлбэр дүрсээр нь зуйван, гурвалжин, дөрвөлжин хэмээн ангилсаар иржээ.

1. **Монгол тамга-өмчлөлийн эрхийн тэмдэг болох нь.**

Монгол тамга нь хувийн өмч буй болохыг дагалдан үүссэн тэмдэг агаад түүнийг үндсэнд нь овог аймгийн ба малын хэмээн ангилдаг. Мөн хадны сүг зурагны дүрс дүрслэлээс улбаалан, аль нэгэн овог аймгийн бэлгэ тэмдэг болж байлаа. Эртний монгол овог аймгууд өөрсдийн эзэмшлийн бэлчээр нутгийнхаа хад чулуун дээр өөрийн овог аймгийнхаа бэлгэ тэмдгийг зурж тэмдэглэн, хил хязгаарынхаа зааг шугамыг тогтоодог уламжлалтай байв. Одоогоор ийм дүрслэл бүхий зургууд нь Монь уул, Шинжааны Алтайн нуруу, ОХУ-ын Буриадын Байгаль нуур орчим, Монгол улсын Хөвсгөл нуур, Богд хан уул гэх зэрэг олон газарт байна. Эдгээр хадны сүг зурганд овог аймгийн болон малын тамга тэмдгийг олон тоотойгоор сийлсэн байдаг бөгөөд эдгээр зурагных нь төрөл зүйл нь ч олон янз байна. Монгол улсын угсаатанзүйн эрдэмтэн Ц.Гочоо малын тамгын тухай зохиолдоо, нийт 360 зүйлийн тамганы хэлбэр дүрс, нэрийг тэмдэглэж үлдээсэн байдаг.

Монгол үндэстний баатарлаг тууль, зүйр цэцэн үг, ардын дуунд тамганы сүр хүч, бэлгэдлийн талаар харуулсан байдаг. (Эртний олон овог аймаг дээрх олон төрлийн тамга тэмдгээр овог аймгийн бэлгэдэл, сүр хүчийг харуулахаас гадна боолуудын хацар дээр нь тамгалж хэрэглэж байгаад хожим хувийн өмчлөлийн малд хэрэглэх болсон байна.)¹ Дэлхийд алдартай Жангарт туульд;

* Дундад улс. Фу Дан их сургуулийн Сонин мэдээллийн дээд сургууль

¹ “Монгол морины соёл судлал”, Өвөрмонголын Ардын Хэвлэлийн хороо., 2001он. 87 дугаар тал.

*Алтайн ноён Жангар богдын боол болъё гэж бодвол
Хүний дунд харцага шувуу
Хүнд гартай савар
Түүний баруун хацар дээр нь бумбын улаан тамгыг тамгалах ²
Баруун гуян дээр нь бумбын алтан тамгатай хүлэг морь
Дөрвөн уулыг давсан ч хөлрөхгүй*

Дөрвөн далайг гаталсан ч ядрахгүй”³ хэмээн өгүүлдэг. Үүнээс үзэхэд, Жангарын овог аймгийнхан боолуудын баруун хацар дээр нь бумбын улаан тамгаараа, харин таван хошуу малынхаа гуянд бумбын алтан тамгаараа тамгалдаг заншилтай байжээ.

Монголчууд урт удаан хугацааны нүүдлийн соёл иргэншлийн туршид таван хошуу малаа ялган таних ур чадварыг хуримтлуулж, өөрийн малаа танихаар барахгүй ойр орчмын малчин өрхүүдийн мал сүргийг ч өөр хооронд нь ялган салгадаг байжээ. Гэвч айл саахалтын ижил зүсмийн малыг ялган танихад маргаан үүсэх нь олон тохиолддог байсан учраас малын им тамга хэрэглэгдэх болжээ. Ертөнцийн гуравт тамга тэмдгийн тухай тэмдэглэсэн утга соёлын үгс маш олон байдаг. Жишээ нь:

*Хүний биед ам нэг гэрч болдог
Өгч авахад баримт нэг гэрч болдог
Үхэр хонинд тамга нэг гэрч болдог
Толгой тэргүүнд малгай нэг гэрч болдог
Хэрүүл маргаанд баримт нэг гэрч болдог*

Мал сүрэгт тамга нэг гэрч болдог, гэх мэтийн хэллэгүүд байдаг. Монгол үндэстний зан үйл судлаач Лувсанчойдон “Монголын зан үйлбэр” бүтээлдээ, эртнээсээ овог аймаг бүр өөрийн тамга тэмдэгтэй байсан бөгөөд одоогийн олон хошууд ч мөн өөрийн тамгатай байсаар байна. Хэдийгээр хошуу болгон нэг л тамгатай байдаг болов ч тухайн тамганы хэлбэр хэмжээгээр нь тэнд оршин суугаа өрхүүдийн амжиргааны төвшин илэрхийлэгддэг. Олон хошуудын хилийн зааг нутаг дэвсгэр болон бэлчээрт нь мал сүрэг холилдон бэлчээрлэдэг болов ч тэдгээрийг тамга тэмдгээр нь ялган мэдэж болно⁴ хэмээн тэмдэглэсэн байна.

Таван хошуу малын им тамга нь эзэмшигч хүний хувийн өмчийн баталгаа болдог. Бусад хүн энэхүү тамгыг өөрчлөх буюу солих, өөрийн хэрэгцээнд ашиглаж болохгүй. Хэрвээ ийм тохиолдол гарвал бусдын шүүмжлэл, дургүйцлийг хүргэхээр үл барам зарим нутагт хулгайн хэрэгт холбогдуулан тооцож, хатуу чангаар залхаан шийтгэдэг байжээ. Хэрвээ тамга тэмдгээ бусдад шилжүүлэх, түүгээр арилжаа худалдаа, солилцоо хийсэн тохиолдолд энэхүү үйлдлээ нийтэд мэдэгдэж, им тамгыг өөрчлөх ёстой. БНХАУ байгуулагдсаны дараахан 1958 оноос эхэлж Өвөрмонголд хувийн өмчийг үгүйсгэж, нэгдэлжих хөдөлгөөнийг өрнүүлэн олон нийтийн дүрэм журмыг хэрэгжүүлжээ. Чингэснээр тухайн нэгдлийн баг, бригад нь өөр өөрийн гэсэн малын им тамгатай болж, түүнийг бригадын няравт тусгайлан хариуцуулж, өөр бусад байгууллагад дур зоргоор ашиглаж хэрэглүүлэхийг хориглох болжээ. 2010 оны зун миний бие Өвөрмонголын Шилийн гол, Монгол улсын Хөвсгөл аймгийн малчин өрхүүдээр явж, хээрийн судалгаа хийх явцад, тухайн орон нутгийн иргэд “Хүн гэрчлэх баримт бүхий паспорттай байдгийн адил мал ч бас гэрчлэх тамгатай. Энэхүү малын тамга нь паспорт юм аа” хэмээн өгүүлцгээж байсан нь сонин бөгөөд ул үндэстэй санаа байв.

² Буянхишиг, Т.Бадмаа, “Жангар” Өвөрмонголын Ардын Хэвлэлийн хороо., 1982он

³ Буянхишиг, Т.Бадмаа, “Жангар” Өвөрмонголын Ардын Хэвлэлийн хороо., 1982он

⁴ Лувсанчойдон, “Монгол зай үйлбэр”, Өвөрмонголын Ардын Хэвлэлийн хороо., 1981 он.

2. Олон төрлийн тэмдэглэгээ бүхий тамганууд нь адил бус соёлын мэдээг дамжуулагч болох нь.

Монгол үндэстний им тамганд адил бус цаг үе, улс гүрэн, улс төрийн тогтолцооны дор ижил бус соёлыг шингээсэн түүхэн ул мөр харагдаж байдаг. Монголчуудын хувьд, нийгэм улс төрийн өөрчлөлт хувиралтын явцад уламжлалт малын им тамгийг яаж хэрхэн тамгалах, ямар цээр хориотой байх, тамгалах орон байр гээд соёл, зан үйл үндсэндээ хэвээр уламжлагдсаар ирсэн. Гэлээ ч малын тамганы хэв загвар шинэ хандлагтай болсоор байжээ. Өвөр Монголын хадны зургын нэрт судлаач Гай Шанг Лин Монь уулын Улаан цавын хадны зургийг судлах явцдаа тэрхүү тамга тэмдэгийг Түрэг бичигтэй адилтган үзэж “хүнийг цочоом адил тал буй” гэж гайхашран ярьжээ.⁵

Монгол үсгийн тамганд уйгаржин монгол, соёмбо, кирилл зэрэг гурван үсгийн тамга тэмдэг байдаг. Одоогоор уйгаржин монгол үсгийн тамгыг Өвөрмонголчууд, Соёмбо үсгийн малын тамгыг Шинжааны Ойрад монголчууд голчлон хэрэглэдэг бол, кирилл үсгийн малын тамгыг Монгол улс тусгаар тогтносоныхоо дараа хэрэглэж эхэлсэн байна. Одоогийн байдлаар уйгаржин монгол болон кирилл үсгийн дүрслэл бүхий малын тамгыг нэлээд түгээмэл хэрэглэж байна.

Манж үсэгтэй тамга бол Монголчууд нь Манжид захирагдсан үеэс эхэлж хэрэглэсэн бөгөөд энэхүү тамгыг хэрэглэсэн нутаг орон олон биш, цаг хугацааны хувьд ч охорхон байсаар одоо нэгэнтээ хэрэглэхээ больсон байна. Төвд үсэгтэй тамга нь Монгол оронд шарын шашин дэлгэрсний дараа Төвдийн соёлын нөлөөлөл дор илэрсэн нэг зүйлийн тамга болно. Одоо ч гэсэн энэхүү төвд үсэгт тамгыг зарим газарт хэрэглэсээр байдаг юм. Хятад үсэгтэй болон Араб тоотой тамгыг голдуу “Хятад улсын соёлын хувьсгал”-ын үед “Дөрвөн хуучин”-ыг устгах улс төрийн хөдөлгөөнийхөн мухар сүсгийг үгүйсгэх үйл ажиллагааныхаа явцад монгол үндэстний уламжлалт малын им тамгыг хэрэглэхийг хязгаарлан хориглосон. Яг энэ онцгой цаг үед Өвөрмонголчууд тухайн цаг үе, улс төрийн үйл ажиллагаанд тохирсон хятад болон араб тоотой тамгыг үүдэн бүтээв. Гэвч өөрчлөлт нээлтийн цаг үе ирэхэд хөдөө тосгоны малчидад хувьчлалын ажлыг хэрэгжүүлэх болсныг дагалдан малчин ард чөлөөлөгдөхөөс өмнө хэрэглэж байсан уламжлалт малын тамгаа дахин сэргээн хэрэглэж эхэлсэн байна.

3. Түмэн үсэгт тамга (уйгаржин монгол үсэг)

Байгаль, цаг уурын эрс тэрс нөхцөл бүхий орчин тойронд уламжлалт мал малалгааны арга, нөхцөл дор мал сүрэг түмэн толгойг давна гэдэг нь тийм ч хялбар хэрэг биш юм. Монголчууд таван хошуу малын дотроос аль нэг төрлийн мал нь түмэн толгой давбал тамганы найр хийж, их хөөр хөгжөөн болцгоодог. Жишээлбэл; Адуун сүрэг нь түмэн толгойг давсан үед тамганы найрыг хийхдээ урьдаар бэлтгэсэн зуун цагаан адуу (азарга болон гүү)-ны ташаан дээр нь түм хэмээх бичиг бүхий тамгыг тамгалдаг. Хэрвээ үхэрийн тоо түмээс давсан тохиолдолд тамганы найрыг хийхдээ урьдаар бэлтгэсэн зуун толгой хүрэн улаан зүсмийн үхрийг тамгалж, найр наадам хийдэг байжээ. Өөр төрлийн мал сүрэг түмээс давбал мөн дээрхтэй адил тамганы найрийг хийнэ. Ингээд гэрийн эзэн хол ойрдоо цуу алдартай том баяны тоонд тооцогдоно.

⁵ Дан Жин, “Монгол соёлын сурвалж бичиг”, Өвөрмонголын Ардын Хэвлэлийн хороо., 1999 он.

4. Тамга тэмдэгийн бэлгэдлийн тухайд.

Монголчуудын хэрэглэж байгаа малын тамга нь зөвхөн өөрийн ба бусдын мал сүргийг ялгах тэмдэг төдий биш харин гүн гүнзгий үндэсний соёлын бэлгэдэлийг агуулж байдаг. Монгол үндэстэн нь малын тамгыг хийх үедээ хэзээд хүмүүсийн бэлиг дэмбэрэлтэй хэв загварыг сонгож, төмрийн дарханаар (заавал тус овог аймгийн хүн байх хэрэгтэй) малын тамгаа давтуулан үйлддэг. Жишээлбэл; нар, сар, од, байгалийн амьтан, ургамал, үйлдвэрлэлийн багаж хэрэгсэл, ахуй амьдралын багаж хэрэгсэл, үсэг бичгээс авахуулаад шашны шүтээний хэв загварыг ч хүртэл тусгадаг байна.

4.1. “Хас тамга” нь монголчуудын түүхийн урт хугацаан дахь хүн малын тухайд холбогдох мэдээллийг дамжуулж байдаг. Цагийн зүүний дагуу хас тамгыг монголчууд бусад тамга, тэмдгээс илүүтэйгээр эрхэмлэдэг бөгөөд мал сүрэгтээ ч хамгийн өргөнөөр ашигладаг тамга тэмдгийн нэг юм. Хуримлаж буй хосууд гартаа шагай атгаж, цагийн зүүний дагуу эргэсэн “хас” тэмдэг бүхий шинэ эсгий дээр сөгдөн тэнгэртээ мөргөх ёслол үйлддэг. Шинэ гэр барьсаны дараа шинэ гэрт орох ёслол хийж, анхны галыг хөгжөөхөд галын тулганы хамгийн доод талд “хас” тэмдэг зурж, дээд талд нь аргал түлж, таван тарианы үр ба цагаан идээ, зандан модны мөчрийг өрж галаа ноцоодог. Хас тэмдгээр угсаа залгамжлан өнөр өтгөн байх, ажил үйлс өөдрөг, эд мөнгөөр элбэг баян, өнө үүрдийн аз жаргалыг бэлгэдэн ирсэн уламжлалтай.

“Хас” тамга нь “чагт” тэмдгээс улбаатай юм. Энэхүү “чагт” тэмдэг нь “Монгол нутгийн хадны зураг дахь үржлийн эрхтэнийг шууд төлөөлж байдаг”⁶ хэмээн тэмдэглэсэн байна.

“Чагт” тэмдэг нь “гай барцадыг арилгаж, биеийг хамгаалах үйлдэлтэй байдаг”⁷ Монгол үндэстний малын тамгын зурагт илэрч байгаа “хас” ба “чагт” тэмдгийн дүрс нь нар шүтлэгийн анхны хэлбэр юм. Мөн нар шүтлэгийн олон шалтгааныг илрүүлж байдгаас гадна “хас” тамганы зөв буруу эргэлт нь нарны гэрлийн тусгалыг илтгэж байдаг. “Маш сонирхолтой учир гэвэл Хятад улсын Сичуаны монголчууд одоо болтол гэрийнхээ хойморт нар, сарны зургийг өлгөж, шүтэн тахидаг уламжлалтай”⁸ ажээ.

4.2. Загасан хэлбэрт тамга нь малын үржил, өсөлтийг бэлгэддэг. Нэн ялангуяа эр эм загасны нийлэлтээр мал сүргийн үржил, өсөлтийг бэлгэдэн дээдэлдэг байна. Монголчуудын эрхэмлэдэг нэгэн чухал зан заншил гэвэл, загас барьж байгаа хүнтэй таарвал хадаг буюу мөнгө барьж загасыг буцаан голд нь тавиулдаг. 1949 оноос өмнө Сөнөд зүүн хошууны малчин Даш алдагдсан мал сүргээ эрж яваад, Баян нуурын хөвөөны эрэгт жаахан амрахдаа нэгэн зүүд зүүдлэжээ. Тэрхүү зүүдэнд нь маш олон загасан хэлбэрт тамгатай цагаан адуу давхин ирээд толгой дээр нь гарав. Тэрээр цочин сэрээд, энэхүү зүүдээ ихэд бэлгэшээн загасан хэлбэртэй тамга хийн адуун сүргээ тамгалжээ. Ингээд удалгүй хол ойрдоо алдаршсан мянган цагаан адуутай баян малчин болсон ажээ. Одоо ч гэсэн энэхүү загасан хэлбэрт тамгыг Сөнөд зүүн хошууны Баян нуур сумын Баян шугуй гацаанд хадгалж буй гэх сурагтай.

Монголчууд загасыг хорин дөрвөн цаг нүдээ цавчдаггүй, сонор сэрэмжтэй амьтан гэж үздэг. Иймээс цаг мөч бүр мал сүргийг хамгаалж, амар амгалан өсөж

⁶ Х.Пэрлээ, “Монгол үндэстний эх үүсэл, тамга тэмдгийн судлал”. УБ., 1975.

⁷ Х.Пэрлээ, “Монгол үндэстний эх үүсэл тамга тэмдэгийн судлал”. УБ., 1975.

⁸ Баяраа нар. “Сичуаны монголчуудын соёл, түүний одоогийн байдал”. Өвөрмонголын нийгмийн шинжлэх ухаан., 1989 он. №4

үржихийг нь бэлгэддэг хэмээн үзсээр ирсэнд энэхүү тамганы утга учир оршиж байгаа юм.

4.3. Шоргоолжин хэлбэртэй тамга нь эрэлхэг баатарлаг, юунаас ч айхгүй, зориг зүрхийг бэлгэддэг. Энэхүү тамга нь монголчуудын малын тамга дотор онцгой хэлбэр дүрстэйд тооцогддог. Монгол үндэстэн жил бүрийн хаврын улиралд малаа хөнгөлдөг бөгөөд хөнгөлсөний дараагаар малын төмсөгийг сүүнд чанаж идэх ба үлдсэнийг нь шоргоолжинд өгдөг ёстой. Энэ нь мал сүргийн үржин өсөхийг бэлгэшээдэг ба нэн чухал нь хүн мал шоргоолжтой адил эрэлхэг баатарлаг, юунаас ч айхгүйгээр хүнд хэцүүг даван туулах гэсэн санааг бэлгэддэг ажээ. Энэ нь монголчуудын урт хугацаанд байгалийн цаг уурын эрс тэрс нөхцөлд амьдарч ирсэнийг илтгэн харуулж байгаа юм.

SUMMARY

Above mentioned earmarks and brands have been used widely among Mongols as they symbolize profound meanings. There are numerous earmarks as well livestock brands with different shapes and forms. These various shaped earmarks and brands involve Mongols thinking of nature of worship and totem worship; also symbolize that peaceful life of people and livestock would be entrusted to blue heaven and earth and number of cattle be increased. This has been a form to be left the facts about Mongolians intangible culture.